



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ТУШААЛ

2018 оны 04 сарын 20 өдөр

Дугаар А/253

Улаанбаатар хот

Удирдамж батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийг үндэслэн, Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 255 дугаар тогтоолоор батлагдсан “Эрүүл шүд-Эрүүл хүүхэд” үндэсний хөтөлбөрийн хэрэгжүүлэх зорилгоор ТУШААХ НЬ:

1. “Цэцэрлэгийн хүүхдийн амны хөндийн эрүүл ахуйг сахих удирдамж”-ыг нэгдүгээр, “Сургуулийн бага ангийн хүүхдийн амны хөндийн эрүүл ахуйг сахих удирдамж”-ыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. “Цэцэрлэгийн насны хүүхдийн амны хөндийн эрүүл ахуйг сахих удирдамж” болон “Сургуулийн бага ангийн хүүхдийн амны хөндийн эрүүл ахуйг сахих удирдамж”-ыг өмчийн бүх хэлбэрийн цэцэрлэг, сургуульд хэрэгжүүлж, үр дүнг тооцож ажиллахыг аймаг, нийслэлийн Боловсролын газрын дарга нарт даалгасугай.
3. Цэцэрлэг, сургуулийн бага ангийн хүүхдийн амны хөндийн эрүүл ахуйг сахих арга хэмжээг зохион байгуулах цэцэрлэг, сургуулийн ажилтнуудын мэдлэг, хандлагыг сайжруулах сургалт зохион байгуулах, мэдээлэл сурталчилгаа явуулж, мэргэшлийн зөвлөгөө, мэдээллээр хангаж ажиллахыг Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн Нүүр, ам судлалын сургууль (Ж.Отгонболд), Нийгмийн эрүүл мэндийн Үндэсний төв (Д.Нарантуяа) -д тус тус үүрэг болгосугай.
4. Удирдамжийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг Нийгмийн эрүүл мэндийн газар /Т.Энхзаяа/, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газарт тус тус даалгасугай.

САЙД



Д.САРАНГЭРЭЛ

Эрүүл мэндийн сайдын 2020 оны
04 сарын 20 өдрийн... дугаар
тушаалын нэгдүгээр хавсралт

**Цэцэрлэгийн хүүхдийн
амны хөндийн эрүүл ахуйг сахих удирдамж**

Нэг. Нийтлэг үндэслэл

Энэхүү удирдамжийн зорилго нь цэцэрлэгийн хүүхдийн амны хөндийн эрүүл ахуйг сахих, шүд цоорох өвчин, түүний хүндрэлээс урьдчилан сэргийлэхэд цэцэрлэгийн хүүхэд, тэдний эцэг эх, асран хамгаалагч, цэцэрлэгийн эрхлэгч, ажилтнуудын хоорондын харилцааг зохицуулахад оршино.

Цэцэрлэгийн насанд хүүхдийн бие махбод, оюун ухаан, мэдрэхүй, нийгэмших үйл явц эрчимтэй явагддаг төдийгүй сүүн шүдний зуулт хэлбэржин, эрүү, хоншоорын ясны хөгжил эрчимтэй явагдаж, ясан буюу байнгын шүд шүдлэхэд бэлтгэгдэж, булчин хөгжсөнөөр, сүүн шүдний хооронд зай үүсэн, ясан шүд эгнээндээ зөв, тэгш сайхан шүдлэх нөхцөл бүрддэг. Иймээс цэцэрлэгийн хүүхдэд шүдээ арчлах зөв дадал, хэвшлийг эзэмшүүлснээр шүд цоорох өвчинд өртөх эрсдлийг бууруулж, түүний хүндрэлээс сэргийлэх боломжтой.

Хоёр. Цэцэрлэгийн эрхлэгч, ажилтнуудын үүрэг

2.1 Цэцэрлэгийн эрхлэгчийн үүрэг:

1. “Эрүүл шүд - эрүүл хүүхэд” үндэсний хөтөлбөрийг дэмжин, хэрэгжүүлж үр дүнг нэгтгэн ажиллах;
2. Цэцэрлэг дотор сахар агуулсан хүнсний бүтээгдэхүүн болон чихэрлэг ундаа худалдаалахгүй, хүүхдэд хэрэглүүлэхгүй байх;
3. Цэцэрлэгийн хичээлийн жилийн төгсгөлд, зуны амралтаар хүүхдээ амны хөндийн эрүүл мэндийн үзлэгт хамруулах үүрэг даалгаврыг эцэг эх, асран хамгаалагчид өгөх, биелэлтэд хяналт тавих;
4. Цэцэрлэгт хийгдэж буй амны хөндийн эрүүл мэндийн боловсрол олгох сургалтыг дэмжин ажиллах;
5. Их үдийн хоолны дараа “Шүд угаах цаг” гаргаж, хөтөлбөрийг зохицуулах;
6. Анги, бүлгийг “Шүд угаах булан”-тай болгож, үйл ажиллагаанд нь хяналт тавих;
7. Цэцэрлэгт хүүхдийн хоолны чиглэлээр мэргэшсэн тогооч ажиллуулж, хүүхдэд шүдэнд ээлтэй хүнс хэрэглүүлэх нөхцлийг бүрдүүлэх;
8. Хүүхдэд өгөх хоол, цай, ундааны сахарын агууламжийг бууруулах чиглэлээр мэргэжлийн байгууллагатай хамтран санаачлагатай ажиллах, тогооч нарыг сургалтад үе шаттай хамруулж байх.

2.2. Цэцэрлэгийн эмчийн үүрэг:

1. Хүүхдийн эцэг, эх, асран хамгаалагчдад зориулсан амны хөндийн эрүүл мэндийн боловсрол олгох сургалтыг жилд 2-оос доошгүй удаа зохион байгуулах төлөвлөгөө боловсруулж, эрхлэгчээр батлуулах;
2. Хүүхдийн шүдний үзлэгийг хийж, эмчилгээ шаардлагатай шүдийг тэмдэглэж, эмчлэн эрүүлжүүлэх үүрэг даалгаврыг ангийн багшаар дамжуулан эцэг эх, асран хамгаалагчид өгч, биелэлтэд хяналт тавих;
3. Анги, бүлгийн “Шүд угаах булан”-ийн үйл ажиллагаа, ариун цэвэрт тогтмол хяналт тавьж, эрүүл ахуйн шаардлагыг хангуулж байх;
4. Багш нарт “Цэцэрлэгийн хүүхдийн амны хөндийн эрүүл ахуй, шүд угаах арга” сэдэвт хичээл бэлдэн танилцуулж, дадлага ажил хийлгүүлэх;
5. Ангийн багш, эцэг эх, асран хамгаалагчидтай хамтран төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган ажиллаж, үр дүнг, удирдлага, эцэг эхчүүдэд танилцуулах.
6. Цэцэрлэгийн хэмжээнд хүүхдийн шүдний өвчлөл, эмчлүүлсэн байдлын талаарх судалгаа, мэдээллийг бүрдүүлсэн байна.

2.3 Багшийн үүрэг:

1. Өөрийн анги, бүлгийн хүүхдийн насны онцлогт тохируулан, хүүхдийн сонирхолд нийцүүлэн “Шүд угаах булан” байгуулах;
2. Их үдийн хоолны дараа, “Шүд угаах цаг”-аар хүүхдийн шүдийг угаалгахдаа, багш өөрөө биечлэн үлгэрлэн, шилэн аяганд ус хийж, сойзыг дүрүүлэн, шүдийг цэвэрлэж, бохирдлыг хүүхдэд харуулан, тайлбарлаж өгч, хүүхэд шүдээ угаах сонирхлыг төрүүлэх;
3. Заасан дарааллын дагуу шүдээ зөв угааж чадаж байгаа эсэхэд хүүхэд нэг бүрд хяналт тавих;
4. Хүүхдийн эцэг эх, асран хамгаалагчдад хүүхдийнхээ шүдийг эрүүлжүүлэх үүрэг өгч, хяналт тавих;
5. Хүүхдийн шүдээ эмчлүүлсэн байдлын талаарх тайлан бичиж, цэцэрлэгийн эмч, удирдлагад мэдээлэх;
6. Хүүхдийн амны хөндийн эрүүл мэндийг сахихад эцэг эхийн үүрэг, хариуцлага чухал болохыг ойлгуулах чиглэлээр байнга санаачлагатай ажиллах.

2.4 Эцэг эх, асран хамгаалагчийн үүрэг:

1. Эцэг, эх гэртээ багшийн заасан аргачлалын дагуу хүүхэдтэйгээ хамт шүдээ угаадаг зуршлыг бий болгох;
2. Хүүхдийг өглөө цайгаа уусны дараа, чихэрлэг зүйл идсний дараа болон унтахын өмнө хүүхдийн шүдийг тогтмол угаалгахад байнга дэмжлэг үзүүлэх;
3. Хүүхдийг цэцэрлэгт хүргэхдээ сахар агуулсан уух зүйлс, хоол хүнсийг авч ирэхгүй байх;
4. Хүүхдэд сахар ихтэй хүнс, хийжүүлсэн болон чихэрлэг ундаа, чихэр, шоколад, амттан бага хэрэглүүлж, хүүхдийн таслах, зулгаах үйлийг сайжруулах, сард

- 1-ээс доошгүй удаа яс мөлжүүлэх, шүлс ихээр ялгаруулдаг исгэлэн амттай, хатуу зажлах үйл шаардсан хүнс хэрэглүүлэх;
5. Эцэг, эхийн амны хөндийд байх нян хүүхдэд халдварлахаас сэргийлж, амнаасаа дамжуулан хоол, ундны зүйл өгөхгүй байх, амны хөндийн үзлэг, эмчилгээнд эцэг эх өөрсдөө байнга хамрагдаж байх;
6. Хүүхдийг жилд 2-оос доошгүй удаа амны хөндийн эрүүл мэндийн үзлэгт хамруулан, шүдийг эмчлэн, эрүүлжүүлсэн тухай шүдний их эмчийн тодорхойлолт, дүгнэлтийг ангийн багшид өгөх;
7. Хүүхдийн насны онцлогт тохирсон шүдний сойз (шүдний сойзны толгойн хэмжээ ойролцоогоор хүүхдийн дээд төвийн үүдэн хоёр шүдний өргөний хэмжээтэй тэнцүү, үс нь 2-3 эгнээ, үсний хатуулаг дунд зэрэг байх)-ыг сонгон бэлтгэж өгөх.




Гурав. Хүүхэд эзэмшсэн байх дадлууд:

1. Хүүхэд ангийн "шүд угаах булан"-д байх өөрийн шүдний сойзоо таньж, зөв байрлуулдаг болсон байх;
2. Шүдээ угаахын өмнө шилэн аяганы дундуур цэвэр ус хийж бэлдэх;
3. Шүдээ угаахдаа ус балгахгүйгээр зөвхөн сойзны үсийг усанд дүрж, норгох;
4. Шүд угаахдаа хэлээрээ шүдээ тэмтрэн, өнгөр байгаа эсэхийг мэдэрч угаах;
5. Эхлээд шүдний өнгөрийг цэвэрлэсний дараа фтортой оо хэрэглэх;
6. Хоол, цай идсний дараа, чихэрлэг хүнс хэрэглэсний дараа, унтахын өмнө шүдээ угаадаг дадалтай болсон байна.

Дөрөв. Хүүхдийн шүд угаах аргачлал:

Хүүхдэд тохиромжтой сойзны толгойн хэмжээ ойролцоогоор дээд үүдэн хоёр шүдний өргөнтэй тэнцүү, үс нь 2-3 эгнээ, үсний хатуулаг дунд зэрэг байна. Угаахдаа:

1. Шүдээ зөөлөн хазаад сойзоо араа шүдний хацар талын гадаргууд хүргээд тойрог хөдөлгөөнөөр хоншоор, эрүүний араа шүдний буйлыг оролцуулан жигд дарж угаана.
2. Үүдэн шүдний таслах ирмэгийг нийлүүлээд мөн тойрог хөдөлгөөнөөр жигд дарж хоншоор, эрүүний үүдэн шүдний буйлыг оролцуулан угаана.
3. Араа шүднүүд, дараа нь үүдэн шүднүүдийн хэл болон тагнай талын гадаргууг мөн тойрог хөдөлгөөнөөр угаана.
4. Хоншоор, эрүүний араа шүдний зажлах гадаргууг тойрог хөдөлгөөнөөр жигд дарж угаана.



Эрүүл мэндийн сайдын 2020 оны
04 сарын 20 өдрийн дугаар
тушаалын хоёрдугаар хавсралт

Сургуулийн бага ангийн хүүхдийн амны хөндийн эрүүл ахуйг сахих удирдамж

Нэг. Нийтлэг үндэслэл:

Энэхүү удирдамж зорилго нь сургуулийн бага ангийн хүүхдийн амны хөндийн эрүүл ахуйг сахих, шүд цоорох өвчин, түүний хүндрэлээс урьдчилан сэргийлэхэд бага ангийн сурагч, тэдний эцэг эх, асран хамгаалагч, сургуулийн захирал, ажилтнуудын хоорондын харилцааг зохицуулахад оршино.

Сургуулийн бага анги буюу 6-10 насанд хүүхдийн бие махбод, оюун ухаан, мэдрэхүй, нийгэмших үйл явц эрчимтэй явагддаг төдийгүй шүд солигдлын үе эхэлж, сүүн шүд ээлж дараалан унаж, байнгын шүд шүдлэн, холимог зуултад шилждэг үе юм.

Иймээс сургуулийн орчинд хүүхдэд шүдээ арчлах зөв дадал, хэвшлийг эзэмшүүлснээр шүд цоорох өвчинд өртөх эрсдлийг бууруулж, түүний хүндрэлээс сэргийлэх боломжтой.

Хоёр. Сургуулийн захирал, ажилтнуудын үүрэг:

2.1 Сургуулийн захирлын үүрэг:

1. “Эрүүл шүд - эрүүл хүүхэд” үндэсний хөтөлбөрийг дэмжин, хэрэгжүүлж үр дүнг нэгтгэн ажиллах, мэдээлэх;
2. Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах;
3. Сургуулийн орчинд сахар агуулсан хүнсний бүтээгдэхүүн болон чихэрлэг ундаа худалдаалахгүй, хүүхдэд хэрэглүүлэхгүй байхад хяналт тавих;
4. Хичээлийн жилийн төгсгөлд, зуны амралтаар хүүхдийг амны хөндийн эрүүл мэндийн үзлэгт хамруулах үүрэг даалгаврыг анги удирдсан багшаар дамжуулан эцэг эх, асран хамгаалагчид өгч, биелэлтэд хяналт тавих;
5. Үдийн хоолны дараа “шүд угаах цаг” гаргаж, шүд угаах нөхцлийг бүрдүүлэх;
6. Сургуулийн эмчийн өрөөнд амны хөндийн эрүүл ахуйг сахихад ашиглах загвар хэрэглэгдэхүүнийг бэлтгэн, Эрүүл мэндийн боловсрол хичээлд ашиглах нөхцлийг бүрдүүлэх;
7. Сургууль дээр “Шүд угаалтын аварга шалгаруулах тэмцээн” зохион байгуулах зэрэг үйл ажиллагааг санаачлан зохион байгуулж, сурагч, ажилтнуудын амны хөндийн эрүүл мэндийн боловсролыг сайжруулах;
8. Сургуульд хүүхдийн хоолны чиглэлээр мэргэшсэн тогооч ажиллуулах, тэднийг мэргэжил дээшлүүлэх сургалтад хамруулж байх;
9. Шүдэнд ээлтэй хүнсний бүтээгдэхүүнийг хүүхдийн Үдийн хоолонд ашиглах, хүүхдэд өгөх хоол, цай, ундааны сахарын агууламжийг бууруулах чиглэлээр мэргэжлийн байгууллагатай хамтран ажиллах

2.2 Сургуулийн эмчийн үүрэг:

1. Сурагч, тэдний эцэг эх, асран хамгаалагчдад зориулсан амны хөндийн эрүүл мэндийн боловсрол олгох сургалтыг жилд 2-оос доошгүй удаа зохион байгуулах төлөвлөгөөтэй ажиллах;
2. Амны хөндийн эрүүл ахуйг сахих талаар сурагч, эцэг эхчүүдэд сургалт, үзүүлэх хичээл хийхэд ашиглах хэрэглэгдэхүүнийг бэлтгэн, ашиглах;
3. Хүүхдийн шүдний үзлэгийг хийж, эмчилгээ шаардлагатай шүдийг тэмдэглэж, эмчлэн эрүүлжүүлэх үүрэг даалгаврыг ангийн багшаар дамжуулан эцэг эх, асран хамгаалагчид өгч, биелэлтэд хяналт тавих;
4. Нийгмийн ажилтан, анги удирдсан багш нартай хамтран сурагчдын шүдийг эрүүлжүүлэх ажлыг зохион байгуулах, үүнд эцэг эх, асран хамгаалагчдыг татан оролцуулах;
5. Сургуулийн хэмжээнд нийт сурагчдын шүдний өвчлөл, эмчлүүлсэн байдлын талаарх судалгаа, мэдээллийн сан бүрдүүлэх;
6. Анги, бүлэгт байх сурагчдын шүд угаах булангийн тохижилт, ариун цэвэрт байнга хяналт тавьж, ангийн багш, жижүүр сурагчаар хэрэгжилтийг хангуулж ажиллана.

2.3 Ангийн багшийн үүрэг:

1. Сурагчдыг шүд угаах хэрэгслээ хадгалах шүүгээтэй болгох;
2. Үдийн хоолны дараа сурагчдын шүдийг тогтмол угаалгах;
3. Сурагчдын эцэг эх, асран хамгаалагчдад хүүхдийн шүдийг эрүүлжүүлэх үүрэг өгч, хяналт тавих;
4. Сурагчдын шүдээ эмчлүүлсэн байдлыг тайлагнан бичиж, сургуулийн эмч, захиралд мэдээлэх;
5. Сурагчдын үдийн хоолны цэсийг хянах, сахар багатай хоол хүнсээр хангах талаар холбогдох хүмүүст санал оруулж байх.

2.4 Эцэг эх, асран хамгаалагчийн үүрэг:

1. Хичээл болон дугуйлан секцэд явуулах үед хийжүүлсэн болон өтгөрүүлсэн ундаа, жүүс, амттан өгөхгүй байх;
2. Шүдний сойзыг зөв сонгох, (сойзны толгой буюу үстэй хэсгийн хэмжээ нь хүүхдийн дээд төвийн үүдэн хоёр шүдний хэмжээтэй, үс нь 2-3 эгнээ, үсний хатуулаг дунд зэрэг) солих шаардлагатай үед цаг алдалгүй шинээр солих;
3. Гэрийн нөхцөлд хүүхдийг хоол, чихэрлэг хүнсний бүтээгдэхүүн хэрэглэсний дараа болон унтахын өмнө заавал шүдийг угаалгаж хэвшүүлэх, шүд угааж байгааг хянах;
4. Хүүхдийг жилд 2 удаа амны хөндийн эрүүл мэндийн үзлэгт хамруулан, эрүүлжүүлсэн тухай шүдний эмчийн тодорхойлолт, дүгнэлтийг анги удирдсан багшид өгөх;
5. Хүүхдэд сахар ихтэй хүнс, хийжүүлсэн болон чихэрлэг ундаа, чихэр, шоколад, амттан бага хэрэглүүлж, хүүхдийн таслах, зулгаах үйлийг сайжруулах, сард 1-ээс доошгүй удаа яс мөлжүүлэх, мах, ногоо, гурил зэргийн хэрчилтийн

хэмжээг томруулах, шүлс ихээр ялгаруулдаг исгэлэн амттай, хатуу зажлах үйл шаардсан хүнс хэрэглүүлэх.

Гурав. Сурагч эзэмшсэн байх дадлууд:

1. Сургууль дээр сахартай ундаа, жүүс, цай, сүү, тараг, ааруул, хатуу чихэр, боов, жигнэмэг зэрэг бүтээгдэхүүнийг авчрахгүй, хэрэглэхгүй байх;
2. Шүдээ угаахын өмнө шилэн аяганы дундуур цэвэр ус хийж бэлдэх;
3. Шүдээ угаахдаа ус балгахгүйгээр зөвхөн сойзны үсийг усанд дүрж, норгоно;
4. Шүд угаахдаа хэлээрээ шүдээ тэмтрэн, өнгөр байгаа эсэхийг мэдэрч угаана;
5. Эхлээд шүдний өнгөрийг цэвэрлэсний дараа фтортой оо хэрэглэж болно;
6. Хоол, цай идсний дараа, чихэрлэг хүнс хэрэглэсний дараа, унтахын өмнө шүдээ угаадаг дадалтай болсон байна.

Дөрөв. Амны хөндийн эрүүл мэндийн буланд тавигдах шаардлага:

1. Анги бүр нь сургуулийн бага ангийн хүүхдийн шүд, амны хөндийг цэвэрлэхэд зориулагдсан амны хөндийн эрүүл мэндийн буюу шүд угаах буланг сурагчдын эцэг эхтэй хамтран байгуулна;
2. Шүд угаах буланг эрүүл ахуйн шаардлага хангасан, хаалгатай, цэвэрлэх, халдваргүйжүүлэх боломжтой гадаргатай материалаар хийгдсэн байна;
3. Шүдний сойз, аяга хадгалах зориулалтын тавиур, эсвэл шүүгээний дотор кварцын гэрэл байрлуулан тогтмол халдваргүйжүүлж, тэмдэглэл хөтлөх;
4. Сурагч бүрийн нэрийг шүдний сойз, аяганд тэмдэглэсэн байх;
5. Шүдний сойзыг аяганд үсийг доош харуулж хадгалах;
6. Төвийн шугамд холбогдоогүй сургуульд хүүхэд бүрийн аяганд хийх усыг зөөврийн ус хадгалах сав болон шүд угаасны дараах бохир усыг цуглуулах хувинтай байх;
7. Хэрэглэж дууссаны дараа сав болон хувинг суллаж хоосон, хуурай байлгах;
8. Хичээлийн жил бүрийн эхэнд сурагч бүр шүдний шинэ сойзтой ирэх ба үс нь хуучирч арзайсан тохиолдолд шинээр солино.

Тав. Хүүхдийн шүд угаах аргачлал

Хүүхдэд тохиромжтой сойзны толгойн хэмжээ ойролцоогоор дээд үүдэн хоёр шүдний өргөнтэй тэнцүү, үс нь 2-3 эгнээ, үсний хатуулаг дунд зэрэг байна. Угаахдаа:

1. Шүдээ зөөлөн хазаад сойзоо араа шүдний хацар талын гадаргууд хүргээд тойрог хөдөлгөөнөөр хоншоор, эрүүний араа шүдний буйлыг оролцуулан жигд дарж угаана.
2. Үүдэн шүдний таслах ирмэгийг нийлүүлээд мөн тойрог хөдөлгөөнөөр жигд дарж хоншоор, эрүүний үүдэн шүдний буйлыг оролцуулан угаана.
3. Араа шүднүүд, дараа нь үүдэн шүднүүдийн хэл болон тагнай талын гадаргууг мөн тойрог хөдөлгөөнөөр угаана.
4. Хоншоор, эрүүний араа шүдний зажлах гадаргууг тойрог хөдөлгөөнөөр жигд дарж угаана.

